

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2025 оны 12 дугаар сарын 25

№02

Улаанбаатар хот

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 01 дугаар тогтоолоор баталсан тус зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 3.7, 3.8-д заасан аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө нь 3 зорилтын хүрээнд 19 арга хэмжээ төлөвлөж, 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэл-85,2% байна. Үүнд:

1.Бодлого, эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилтын хүрээнд 4 арга хэмжээ төлөвлөснөөс гүйцэтгэлийн хувь- 100%

2.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээг сайжруулах зорилтын хүрээнд 4 арга хэмжээ төлөвлөснөөс гүйцэтгэлийн дундаж хувь- 57,5%

3.Дэд, салбар зөвлөлийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх зорилтын хүрээнд 11 арга хэмжээ төлөвлөснөөс гүйцэтгэлийн дундаж хувь- 88,1%-ийн биелэлттэй байна.

Дүгнэлт: Төлөвлөсөн 19 арга хэмжээнээс 2025 оны жилийн эцсийн байдлаар 10 арга хэмжээ бүрэн хангалттай хэрэгжсэн буюу 100% гүйцэтгэлтэй, 7 арга хэмжээ хангалттай хэрэгжилттэй боловч зохион байгуулалт хариуцлагыг сайжруулах шаардлагатай буюу 70%-85%-ийн гүйцэтгэлтэй, 2 арга хэмжээ зорилтот түвшинд хүрээгүй буюу хэрэгжилт хангалтгүй 30%-50%-ийн гүйцэтгэлтэй байна.

Дээрх дүгнэлтээс үзэхэд 2025 оны жилийн эцсийн байдлаар зөвлөлийн үйл ажиллагааны хэрэгжилт бүрэн хангалттай гэсэн үнэлгээний хязгаарт багтаж байгаа хэдий ч төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд цаашид үр дүнгийн үзүүлэлтийг сайжруулж, төлөвлөлтөд анхаарах шаардлагатай гэж дүгнэж байна.

Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээг сайжруулах зорилтын хүрээнд төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулах, эрчимжүүлэх, улмаар 2026 оны төлөвлөлтөд үндэслэлтэй, тооцоолол бүхий үр дүнд чиглэсэн арга хэмжээнүүдийг түлхүү тусгаж төлөвлөх шаардлагатай байна.

Дэд болон салбар зөвлөлүүд нь тайланг хугацаандаа ирүүлсэн хэдий ч тайлагналтдаа үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнд нийцсэн тайлагналт хийгээгүй, тухайн арга хэмжээний гол үр дүнг нэгтгээгүй, үр дүн тодорхой бус тайлагналт ирүүлэх нь нийтлэг байна.

Тухайлбал: Үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.7-д тусгагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх нөлөөллийн сургалтыг зохион байгуулах гэсэн арга хэмжээнд шалгуур үзүүлэлтийг сургалтад хамрагдах албан хаагчдын тоо гэж төлөвлөж, энэ арга хэмжээ нь төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулахаар ойлгогдох байтал арга хэмжээний агуулгад нийцээгүй тайлагналт хийсэн.

Мөн түүнчлэн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт нь хагас жилийн тайлагналтаас өссөн үзүүлэлтгүй, хагас жилээс хойш хийсэн ажлын тайлагналт байхгүй, шалгуур үзүүлэлт оновчгүй тодорхойлсноос тухайн арга хэмжээний үр дүнг хэмжиж, үнэлэх боломжгүй зэрэг нийтлэг алдаа дутагдлууд байна.

Цаашид анхаарах асуудал

1. Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн гүйцэд тайлагнаж байх, явцын хяналт тавьж эрчимжүүлэх шаардлагатай зүйл, заалтын хэрэгжилтийг хангуулах;

2. Төлөвлөлтийн шалгуур үзүүлэлтийг хэмжигдэхүйц, оновчтой буюу SMART (тодорхой, хэмжихүйц, хүрч болохуйц, бодит үр дүнд чиглэсэн, цаг хугацаатай) зарчмаар тодорхойлох;

3. Төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй буюу огт хэрэгжээгүй байгаа арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг сайжруулж, үр дүнг нэмэгдүүлэх талаар онцгой анхаарч ажиллах;

4. Дэд болон салбар зөвлөлүүдээс үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан зорилго, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайлан, мэдээг тогтоосон хугацаанд чанартай гаргуулан авч нэгтгэн, тухай бүрд хэрэгжилтийн явцыг дүгнэн, удирдлагад мэдээлж, эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаар тодорхой ажил зохион байгуулж үр дүнг тооцож байх;

5. Зөвлөлийн ажлын албаны үйл ажиллагааг эрчимжүүлж, дэд болон салбар зөвлөлүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар бүрэн хангаж, төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, зөвлөлийн хуралдаанд танилцуулж хэлэлцүүлэх;

6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд болон салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, уялдаа холбоог сайжруулах, чадавхижуулах, уг салбар зөвлөлийн үндсэн чиг үүргийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгч үүрэг, хариуцлага тооцох, хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

ТАНИЛЦСАН:

ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

Д.ГЭРЭЛ

ХЯНАСАН:

ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН
ГАЗРЫН ДАРГА

Л.БАТМӨНХ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Ч.МӨНХСАЙХАН